



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

**Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний  
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар нийт 89,332,255 (наян есөн сая гурван зуун гучин хоёр мянга хоёр зуун тавин таван) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын хэрэгжилт 90.1 хувь буюу “Тодорхой үр дүнтэй хүрсэн” гэж дүгнэсүгэй.

2.“Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.“Хөвсгөл дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Д.Цанлигрэнчин)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах;

3.2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, гүйцэтгэх захиралтай байгуулсан “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ээр олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний үзүүлэлт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал, хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй, хэмнэлттэй, үр ашигтай ажиллах;

3.3.Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;

3.4.Компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ус дулаан дамжуулах төвүүдийн барилгад хамаарах, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа газар эзэмших эрхийг шилжүүлэн авч үнэлж, үндсэн хөрөнгөд бүртгэх арга хэмжээ авах;

3.5.Авто осолд орсон ХӨ 01-11 улсын дугаартай тээврийн хэрэгслийн хохирлыг үнэлүүлж, барагдуулах, ашиглалтад оруулах арга хэмжээ авах;

3.6.Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн данс хооронд үндсэн хөрөнгө шилжүүлэхдээ төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хандаж зөвшөөрөл авч байх;

3.7.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн  
172 дугаар тогтоолын хавсралт



“Хөвсгөл дулаан станц” төрийн өмчит хувьцаат компанид хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /сая.төг/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээг тусгасан.	1.8	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4	Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх.
2	Үргүй зардал гаргасан.	6.8	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол	Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.
3	Хөрөнгө зөвшөөрөлгүй бүртгэлд тусгасан.	15.9	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271-р тогтоолоор батлагдсан журам	Хууль болон холбогдох журмыг мөрдөж ажиллах.
4	Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг үнэлж бүртгээгүй.	64.7	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271-р тогтоолоор батлагдсан журам	Хөрөнгийг цаашид ашиглах жилийг тогтоон үнэлж бүртгэх.
5	Ус дулаан түгээх төвүүдийн газар эзэмших эрхийг шилжүүлэн авч баталгаажуулаагүй.	-	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль	Хөвсгөл ус суваг ХХК болон бусад этгээдийн эзэмшил дэх шилжүүлэх шаардлагатай газар эзэмших эрхийг баталгаажуулж авах.
6	Дүрэм зөрчиж техникийн нөхцөл олгосноос үйлдвэрлэлийн зардал нэмэгдэж төрийн өмчийн үр ашиг буурах нөхцөлийг бүрдүүлсэн.	-	Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм	Дулааны шугамын 1-р хэлхээнээс УДДТ-ийн өргөтгөлгүй хэрэглэгч холбохгүй байх, зөрчлийг арилгаж холбогдох хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм мөрдөж ажиллах.
Нийт дүн		89.3 (наян есөн сая гурван зуун мянга)		